

Засгийн газраас баталсан “Сүү” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн
хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл								
1	Хөтөлбөрийг баталсан огноо	Засгийн газрын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 239 дугаар тогтоол								
2	Хөтөлбөрийн зорилго	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж, нэр төрлийг нэмэгдүүлэх, түүний чанар, эрүүл ахуй, ариун цэврийн түвшинг дээшлүүлэх, дотоодын хэрэгцээгээ хангах, экспортлох нөхцлийг бүрдүүлэх								
3	Хөтөлбөрийн зорил-тууд /Үе шатны хугацаатай нь авч үзэх/	2007-2012 он	1. Сүү, цагаан идээний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжлийн эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлэх 2. Төв суурин газрын ойролцоо сүүний эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, малчин өрх, фермер, үйлдвэрүүдийн хоршин ажиллах санаачилгыг дэмжих 3. Сүү боловсруулах, савлах бага хүчин чадалтай тоног төхөөрөмжийн импорт, үйлдвэрийг дэмжин, сум, багийн түвшинд нэвтрүүлж, сүү, сүүн бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн түвшинг сайжруулах 4. Зохицуулах үйлчилгээтэй сүү, сүүн бүтээгдэхүүн, сувиллын болон хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх 5. Сүү, цагаан идээний ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа өрнүүлэн, хүүхэд залуучуудын дунд сүү, цагаан идээний хэрэглээг нэмэгдүүлэх замаар импортыг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих							
		2013-2016 он								
4	Зардал /сая төг/	Төсөв	Хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэрийг заасан хэдий ч зарцуулах хөрөнгийн хэмжээг тогтоогоогүй болно							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	1418.0 сая төг/хөтөлбөрийн санхүүжилт/+2000.0 сая төг/Сүү төслийн санхүүжилт/. Бүгд 3418.0 сая төг.							
		Үүнээс тухайн жилд зарцуулсан	450.0 сая төг/хөтөлбөрийн санхүүжилт/+150.0 сая төг/НҮБ-ын Сүү төслийн санхүүжилт/. Бүгд 6000.0 сая төг.							
5	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	5			3	2			
6	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Суурь онд			Тайлант оны гүйцэтгэл			Хувь	
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	1. Малын тэжээлийн үйлдвэрлэлийн өсөлт, %	2006 онд 25.0 мян.т			26.3 мян.т			105.2	
		2. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйн өсөлт, %	2006 онд 252			523			207.5	
		3. Үнээний тооны өсөлт, %	2006 онд 5975			19298			323.0	

		4. Саалинд хамрагдах малын тооны өсөлт, %	2006 онд 6518 мян	8098 мян	124.2
		5. Үйлдвэрийн ар-гаар боловсруул-сан сүүний хэмжээ	2012 онд 2005 /7.1 сая л/ оныхоос 5 дахин нэмэгдэж, 2016 онд ХАА-д бэлтгэсэн нийт сүүний 20 %-д хүргэх	14 сая.л	197.2
		6, Нийт сүүнд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан сүүний эзлэх хувь, %	2005 онд 1.7 хувь байсан	3.1 хувь	182.3
		7.Сүүний шинжил-гээний цэг, лабораторийн тоо	2006 онд 94	115	122.3 %
		8. Нэг хүн амын сүүний хэрэглээ,л: -хотод -хөдөөд	2006 онд 68.4 232.8	87.6 220.8	128.1 94.8
		9. Импортлосон сүүний хэмжээ.мян.т	2006 онд- 9.3	19.9	214.0%
		10. Шинээр бий болсон ажлын байрны тоо	Мэдээлэл байхгүй	110	70.0
		11. Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо	Төлөвлөөгүй. 2006 онд 490	566	115.5
7	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц	Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш хоногт 1 т сүү боловсруулах 7 жижиг үйлдвэр, хоногт 200 л сүү хөргөж савлах цех 22, хоногт 1000-5000 л сүү хүлээн авч хөргөх 22 төв, 50-100 л сүү боловсруулах жижиг оврын 70 ш иж бүрдэл төхөөрөмж, сүү боловсруулах зөөврийн 5 ш байр, сүү шинжилгээний 25 ширхэг багаж, сүү зөөх бидон 400ш, хөргөлттэй цистернтэй сүүний автомашин 5 ширхэгийг худалдан авч нийлүүлсэн. 45 үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдэд 917.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Дотоодод 670 гаруй, гадаадад 62 хүнийг сургалтад хамруулжээ. Сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдааг жилд 2 удаа зохион байгуулж хэвшээд байна. Сүүний чиглэлийн эрчимжсэн 271 аж ахуй, шинээр байгуулагджээ. 2008 онд нийлүүлсэн сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулсан.			
8	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	Улсын болон орон нутгийн төсөв, банкны зээл, гадаадын зээл, тусламжийн хүрээнд хөтөлбөрийн санхүүжилтэд мэдэгдэхүйц ахиц гарснаар сүү үйлдвэрлэл, боловсруулалтын бизнес эрхлэгчдийн болон сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн тоо, боловсруулсан			

		сүүний хэмжээ нэмэгдэж байна. Улсын төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийг ашиглан сүүг үйлдвэрийн аргаар боловсруулах хүчин чадал аймаг, сумдад сайжрах боломжийг бүрдүүлж байна. 2009 онд гэхэд 7.4 сая литр сүү боловсруулах хүчин чадлыг шинээр бий болгож, 710 орчим малчид фермерүүдээс сүү авч боловсруулах боломж бүрдүүлжээ.
9	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал	Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгө оруулалтыг урдчилан төлөвлөөгүй тухайн үеийн улсын эдийн засгийн боломжид тулгуурлан санхүүжилт хийж байгаа болохоор хүлээгдэж буй үр дүнг он оны хүрэх түвшингээр тогтоох боломжгүй. Харин хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнөх 2006 оны үзүүлэлттэй харьцуулахад ихэнх үзүүлэлт өссөн байдалтай байна. Эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр “Хүнсний тухай” хуульд зарим өөрчлөлт оруулсан хуулийн төслийг ХХААХҮЯ бэлтгэж байна. Энэ үйл явц маш удаашралтай, одоо бараг 3 дахь жилийн нүүрийг үзэж байна. Нөгөө талаар төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, өгөөжид тавих хяналт сул, яам тендер зарлан холбогдох бараа, үйлчилгээг худалдан аваад хөтөлбөрийн үр шимийг хүртэгсдэд хуваарилан өгснөөр ажлаа хязгаарлаж, үр дүн, өгөөжид муу анхаарч байна. Энэ талаар 2009 онд ахиц гараагүй.
10	Эдгээрээс гарах арга зам	-Хүнсний тухай хуулийн шинэчлэн боловсруулж, батлуулж, мөрдүүлэх ажлыг шуурхай гүйцэтгэх. -Хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, олгосон зээлийн эргэн төлөлтийг сайжруулах. -Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтүүдийг боловсронгуй болгож, онд хүрэх түвшинг тогтоох -Хөтөлбөрийн өдөр тутмын удирдлага зохион байгуулалтыг сайжруулах -Хөтөлбөр хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөний боловсруулалтын чанар, гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулах, хөтөлбөрийн зорилтод чиглүүлэн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх -Хөтөлбөрийн гүйцэтгэлийн мониторингийн тогтолцоо бий болгох -Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн тайлан мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудын түвшинд онцгой анхаарч арга хэмжээ авах.
11	Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	ХХААХҮ-н сайдаар ахлуулсан Хүнсний салбарын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үндэсний хорооны бүрэлдэхүүнийг холбогдох талуудын оролцоог хангахуйцаар бүрдүүлсэн ч үйл ажиллагаа нь хангалтгүй байна. Гэхдээ хөтөлбөрийн ажлын багийн бүрэлдэхүүн болоод жилийн ажлын төлөвлөгөөнд энэ асуудал бүрэн тусгалаа олоогүй байна.
12	Хөтөлбөрийн талаарх яамны санал / өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	-Хөтөлбөрийн үр ашиг, үр өгөөж, үр нөлөөг үнэлэх үзүүлэлтүүдийг боловсронгуй болгож хүрэх түвшинг тодорхой болгож хөтөлбөрт суулгаж өгөх -Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг урт хугацааны төлөвлөлтийн үндсэн дээр нэмэгдүүлэх

13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаархи санал/дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/	<p>-Аймаг, нийслэл бүр сүү хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Гэхдээ тухайн хөтөлбөрийн төлөвлөлтийн чанар чансааны талаар хөтөлбөрийн үндэсний хороо, ХХААХҮЯ-ны зүгээс зөвлөлгөө зөвлөмж өгөх</p> <p>-Жилд 2-3 аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг Үндэсний хорооны хурлаар хэлэлцэж байх.</p> <p>-Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.</p>
----	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА